



**МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ
ЭРХИЙН БАТЛАМЖ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ**

**Улаанбаатар хот
2023 он**

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийг 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Мэргэшсэн хуульч нэршил хэрэглэх эрхийн батламж, түүнийг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

П.ОДГЭРЭЛ

“МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ” НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ ЭРХИЙН БАТЛАМЖ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульчдад мэргэшсэн чиглэлээр нь “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох, түүнийг цуцлах үйл ажиллагаа болон мэргэшсэн хуульчдад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоож хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох эрх бүхий байгууллага нь энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан төлөөллөөс бүрдсэн “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох “Ажлын хэсэг” /цаашид “Ажлын хэсэг” гэх/ байна.
- 1.3. “Ажлын хэсэг” нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4. Энэхүү журмын Хавсралтууд нь журмын нэгэн адил хүчинтэй байх бөгөөд журам болон Хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Монголын Хуульчдын холбооны зөвлөл шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ “МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ”-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. “Мэргэшсэн хуульч” нэршлийг хэрэглэх хуульч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан шаардлагыг бүхэлд нь хангасан байх;
 - 2.1.2. Сүүлийн 3 жил хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчиж, мэргэшсэн чиглэлээр хариуцлага хүлээгээгүй байх;
 - 2.1.3. Энэхүү журмын 3.1 дэх хэсэг болон журмын Хавсралтад заасан өөрийн мэргэших сонирхол бүхий салбар эрх зүйн тусгайлсан шаардлагыг хангасан байх.
- 2.2. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх хүсэлт гаргасан хуульч нь тухайн мэргэшсэн салбар эрх зүйн чиглэлээр өгүүлэл нийтлэл бичсэн, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт илтгэл тавьж оролцсон бол давуу тал болно.
- 2.3. “Мэргэшсэн хуульч” нэршлийг хэрэглэх хуульч нь энэхүү журмын 2.1-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 2.3.1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 6-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх;
 - 2.3.2. Сүүлийн гурваас доошгүй жил мэргэших сонирхол бүхий эрх зүйн чиглэлээрээ зөвлөгөө, туслалцааг тасралтгүй үзүүлсэн, хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд тогтмол оролцсон эсхүл тухайн чиглэлээр хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчээр ажилласан, хуулийн төслийн ажлын хэсэгт оролцож, өөрийн саналыг тусгуулсан байх;

- 2.3.3. Мэргэших сонирхол бүхий салбар эрх зүйн чиглэлээр зохих мэдлэгтэй болохыг нотлосон баримтуудыг энэхүү журмын Хавсралтад заасны дагуу ирүүлсэн байх;
- 2.3.4. Энэхүү журмын 2.1.1-д заасан хуульчийн үргэлжилсэн сургалтаас гадна Монголын Хуульчдын холбооны Сургалтын хорооноос магадлан итгэмжлэгдсэн “Мэргэшүүлэх сургалт”-д хамрагдсан байх;
- 2.3.5. Энэхүү журмын Хавсралтад заасан өөрийн мэргэшиж буй салбар эрх зүйн тусгайлсан шаардлагыг бүхэлд нь хангасан байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
“МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ” НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ
ЭРХИЙН БАТЛАМЖ, ТҮҮНИЙГ ОЛГОХ

- 3.1. Энэхүү журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлага хангасан хуульчдад шүүхийн өмнө төлөөлөх иргэн, эрүү, захиргааны эрх зүйн салбарын төрөл, чиглэлээр “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламжийг олгоно.
 - 3.2. “Мэргэшсэн хуульч” нэршлийг хэрэглэх хуульчид тавигдах тусгайлсан шаардлагыг энэхүү журмын Хавсралтаар батална.
 - 3.3. Хуульч нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн “Ажлын хэсэг”-т “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх хүсэлт гаргана. Үүнд:
 - 3.3.1. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж авахыг хүссэн өргөдөл;
 - 3.3.2. Мэргэжлийн диплом, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ, хуульчийн мэргэжлийн үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/
 - 3.3.3. Хуульчийн ажиллаж буй өмгөөллийн хуулийн этгээд болон өөрийн ажиллаж буй хуулийн этгээдийн ажил байдлын тодорхойлолт; /Аливаа хуулийн этгээдэд байнгын ажил эрхэлдэггүй бол Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хорооноос авсан ажил байдлын тодорхойлолт/
 - 3.3.4. Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цагийг хангасан эсэх тодорхойлолт;
 - 2.3.6. Мэргэшиж буй салбар эрх зүйн чиглэлээрээ тогтмол хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн, хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон эсхүл тухайн чиглэлээр хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчээр ажилласан, хуулийн төслийн ажлын хэсэгт оролцож, өөрийн саналыг тусгуулсан эсэхийг нотлох баримтууд;
 - 3.3.5. Нэмэлтээр өөрийн хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, нийтлэл, судалгааны ажил зэргийг бичгээр эсхүл файлаар хавсаргаж болно.
- 3.4. “Ажлын хэсэг” нь хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг шалгаж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлагуудыг хангасан эсэхэд дүгнэлт өгнө.
 - 3.5. “Ажлын хэсэг”-ийн хурлаар “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.
 - 3.6. Энэхүү журмын 3.5 дахь хэсэгт заасан тогтоолыг үндэслэн Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч тушаал гаргах бөгөөд холбооны Тамгын газар “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох үйл ажиллагааг хариуцан зохион байгуулна.
 - 3.7. Энэхүү журмын 3.6 дахь хэсэгт заасны дагуу “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхтэй болсон хуульчдын нэрсийн бүртгэлийг хөтөлж, Монголын Хуульчдын холбооны албан ёсны цахим хуудаст байршуулан, нийтэд зарлана.

- 3.8. Энэхүү журмын 3.5 дахь заалтад заасны дагуу эрхийн батламж аваагүй хуульч “Мэргэшсэн хуульч” нэршлийг хэрэглэх эрхгүй.
- 3.9. Энэхүү журмын 3.8-д заасныг зөрчсөн хуульчид Монголын Хуульчдын холбооноос зөрчлийг арилгах мэдэгдлийг хүргүүлж, сануулах арга хэмжээ авна.
- 3.10. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламжийн хураамжийн хэмжээг Монголын Хуульчдын холбооны зөвлөл тогтооно.
- 3.11. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэж байгаа хуульч нь өөр эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч нэршил хэрэглэх хүсэлтийг “Ажлын хэсэг”-т гаргах эрхтэй. Энэ тохиолдолд энэхүү журмын 3.3-т заасан баримт бичгүүдийг бүрдүүлж, “Ажлыг хэсэг”-т хүсэлтийн хамт ирүүлэх ба “Ажлын хэсэг” нь тухайн эрх зүйн чиглэлээр “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх батламж олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
“МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ” НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ ЭРХИЙН БАТЛАМЖ
ОЛГОХ “АЖЛЫН ХЭСЭГ”-ИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

- 4.1. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох “Ажлын хэсэг” нь дараах хороодын төлөөллөөс бүрдсэн нийт 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
 - 4.1.1. Сургалтын хорооноос хоёр гишүүн;
 - 4.1.2. Иргэний эрх зүй, Захиргааны эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүй, Олон улсын эрх зүй, Эдийн засгийн эрх зүйн 6 сайн дурын хороодоос тус бүр нэг гишүүн;
- 4.2. “Ажлын хэсэг”-ийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 4.2.1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 10-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх;
 - 4.2.2. Энэхүү журмын 4.1-д заасан хороодын Удирдах зөвлөлийн 100 хувийн саналаар “Ажлын хэсэг”-т томилогдсон байх;
 - 4.2.3. Энэхүү журмын 4.1-д заасан өөрийн төлөөлж буй хорооны үйл ажиллагаанд 3-аас доошгүй жил гишүүнээр оролцсон байх.
- 4.3. Тамгын газар нь энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан хороодын Удирдах зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн “Ажлын хэсэг” байгуулах ажлыг хариуцан зохион байгуулна.
- 4.4. “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг Монголын Хуульчдын холбооны зөвлөл баталж, тогтоол гаргана.
- 4.5. “Ажлын хэсэг”-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд “Ажлын хэсэг”-ийн даргыг бүх гишүүдийн саналаар сонгож, тогтоолоор баталгаажуулна.
- 4.6. “Ажлын хэсэг”-ийн ээлжит хурлыг хагас жилд нэг удаа заавал хуралдуулах ба ээлжит бус хурлыг “Ажлын хэсэг”-ийн дарга эсхүл гишүүдийн олонхын саналаар тухай бүр зарлан хуралдуулж болно.
- 4.7. “Ажлын хэсэг”-ийн ээлжит болон ээлжит бус хурал нь нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөрт тооцогдох ба “Ажлын хэсэг”-ээс гарсан шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.
- 4.8. “Ажлын хэсэг” нь энэхүү журмын 3.4 дэх хэсэгт заасны дагуу “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж олгох үйл ажиллагааг зохион байгуулахдаа тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг урьж оролцуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

- 5.1. Мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах эрх бүхий этгээд нь Монголын Хуульчдын холбооны Сургалтын хороо байх бөгөөд хөтөлбөрийг магадлан итгэмжилсэн байна.
- 5.2. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламж авах хүсэлтэй хуульч нь Монголын Хуульчдын холбооны Сургалтын хорооноос зохион байгуулах мэргэшүүлэх сургалтад заавал хамрагдсан байна.
- 5.3. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэж байгаа хуульч нь жил бүр Сургалтын хорооноос зохион байгуулсан ахисан түвшний мэргэшүүлэх сургалтад хамрагдах үүрэгтэй ба сургалтад хамрагдсан нь “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийг сунгах үндэслэл болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

“МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ” НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ ЭРХИЙН ХУГАЦАА, ТҮҮНИЙГ СУНГАХ

- 6.1. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламжийг 5 жилийн хугацаатай олгоно.
- 6.2. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламжийн хугацаа дууссан хуульч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн хугацааг 5 жилээр сунгана. Үүнд:
 - 6.2.1. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийн батламжийн хугацаа сунгах хүсэлт гаргасан байх;
 - 6.2.2. Энэхүү журмын 3.3.3-3.3.6-д тус тус заасан баримт бичгийг бүрдүүлсэн байх;
 - 6.2.3. Энэхүү журмын 5.3-т заасан мэргэшүүлэх сургалтад жил бүр хамрагдсан байх ба Сургалтын хорооны тодорхойлолтыг хүсэлтэнд хавсаргана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

“МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ” НЭРШИЛ ХЭРЭГЛЭХ ЭРХИЙГ ЦУЦЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

- 7.1. Ажлын хэсэг нь дараах тохиолдолд “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийг цуцална. Үүнд:
 - 7.1.1. “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх эрхийг цуцлуулах тухай хүсэлтийг өөрөө гаргасан;
 - 7.1.2. Тухайн мэргэшсэн салбар эрх зүйн хорооны гишүүнчлэлээс гарсан;
 - 7.1.3. “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.6 болон 22.7-д заасан үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болсон.
- 7.2. “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.3 болон 22.5 дахь хэсэгт заасны дагуу Монголын Хуульчдын холбоо хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх болон сэргээх асуудлыг шийдвэрлэхдээ “Мэргэшсэн хуульч” нэршил хэрэглэх асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

- 8.1. Энэхүү журмыг Монголын Хуульчдын холбооны зөвлөл баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 8.2. “Ажлын хэсэг”-ийн үйл ажиллагаанд Зөвлөл хяналт тавьж ажиллах бөгөөд “Ажлын хэсэг”-ийн шийдвэртэй холбоотой аливаа гомдол, саналыг Зөвлөл шийдвэрлэнэ.
- 8.3. “Ажлын хэсэг” нь энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллах ба журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлд гаргах эрхийг эдэлнэ.